

“Музей ба цуглуулгыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн олон төрөл болон нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар зөвлөмж”

ЮНЕСКО-гийн 38 дугаар Ерөнхий бага хурал Парис хотноо 2015 оны 11 дүгээр сарын 17-нд “Музей ба цуглуулгыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн олон төрөл болон нийгэмд гүйцэтгэх үүргийн тухай зөвлөмж”-ийг баталсан нь музейн хөгжилд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо. ЮНЕСКО музейн чиг үүрэг, нийгэмд гүйцэтгэх үүрэг, өнөө үед музейн өмнө тулгарч буй асуудлуудын талаар гишүүн орнуудад хандан зөвлөмж гаргаж, түүнд тогтоосон зарчим ба хэм хэмжээг амьдралд хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн баримт бичиг гаргах зэргээр шаардлагатай арга хэмжээ авахыг гишүүн орнуудад зөвлөсөн байна. Уг зөвлөмжийг ЮНЕСКО ба Олон улсын музейн зөвлөл хамтран боловсруулжээ.

Зөвлөмжийн “Нийгэмд музейн өмнө тулгамдаж буй асуудал” хэсэгт музей нь эдийн засаг, амьдралын чанарын асуудалд хамааралтай болохыг онцолсон байна. “Гишүүн орнуудыг музей нь нийгмийн амьдралд эдийн засгийн үүрэг гүйцэтгэж, орлогыг бий болгоход хувь нэмэр оруулж чадах байгууллага болохыг хүлээн зөвшөөрөх, музей нь аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа ба бүтээлч төслүүдийн хэрэгжилтэд оролцох замаар оршин буй бүс нутаг, хүн амын бүлгийн амьдралын чанарыг дээшлүүлдэг, эмзэг бүлгийн хүмүүсийг нийгмийн амьдралд ороход тусалдаг. Олон музей санхүүжилтийн төрөл бүрийн эх үүсвэрийг бий болгох, санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх үүднээс өөрийн санаачлагаар, эсвэл хэрэгцээ шаардлагын улмаас орлого олох үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Гэхдээ орлого олох үйл ажиллагаанд тэргүүн зэргийн ач холбогдол өгч, музейн үндсэн чиг үүрэгт (хадгалах, судалгаа, коммуникаци ба боловсролын) хор хохирол учруулахгүй байх, нийгэмд маш чухал ач холбогдолтой музейн эдгээр чиг үүрэг нь дан ганц санхүүгийн үзүүлэлтээр илэрхийлэгдэхгүй юм гэдгийг гишүүн орнууд хүлээн зөвшөөрөх нь зүйтэй” гэжээ.

Түүнчлэн зөвлөмжийн “Үйл ажиллагааны бодлого” хэсэгт “Музейн үр өгөөжтэй үйл ажиллагаа нь улс, хувийн санхүүжилт ба тогтоосон харилцаа холбооноос шууд хамаардаг. Гишүүн орнууд музей нь үндсэн чиг үүргээ бүх талаар хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхны төлөө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжоор хангагдсан байхын тулд тодорхой алсын хараа, зохистой төлөвлөлт болон санхүүжилттэй байх, түүнчлэн төрөл бүрийн санхүүжилтийн тэнцвэрийг хангах талаар хүчин чармайлт гаргах нь зүйтэй” гэжээ.

Музейн үндсэн чиг үүрэг

- ▶ **Хадгалах:** Музейд үзмэр авах, цуглуулгын менежмент
- ▶ **Судалгаа:** Цуглуулгын судалгааны дүнд музей нөөц боломжоо бүрэн дүүрэн ашиглаж, олон нийтэд хүргэнэ.

- ▶ **Коммуникаци:** Цуглуулга ба түүх соёлын дурсгалын тухай мэдлэгийг идэвхтэй түгээж, үзүүлэх ёстой. Нийгэмд идэвхтэй үүрэг гүйцэтгэхийн тулд харилцааны бүхий л хэлбэрийг ашиглана. Тухайлбал, төрөл бүрийн арга хэмжээ, бусад соёлын үйл ажиллагаанд бодитоор ба цахим хэлбэрээр оролцоно.
- ▶ **Боловсрол:** Мэдлэг олгох, боловсрол болон хүмүүжлийн хөтөлбөрүүдийг бий болгох, хөгжүүлэх, дамжуулах замаар албан, албан бус ба насан туршийн боловсролд оролцоно.

www.portal.unesco.org/en

Бэлтгэсэн Д.Бумаа Ph.D, дэд проф.

/МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга/